Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
Тамгын газрын даргын 2025 оны ..... сарын
....-ны өдрийн ..... дугаартай албан бичгийн
хавсралт

## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

## НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ "АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ"-НИЙ ХЭРЭГЖИЛТ

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Хүрэх түвшин, үр дүн | Зарцуулах хөрөнгө мян/төг | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжил-тийн хувь | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг:<br>а/байгууллагын албан ёсны цахим хуудас;<br>б/сошиал сувгууд;<br>в/дотоод сүлжээ;<br>г/хэвлэл мэдээллийн хэрэгсэл;<br>д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц;<br>е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх; | -Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх;<br>-Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрт тайлагнадаг байх;<br>-Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших;<br>-Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. | Жилдээ | Сар бүр цахим хуудсанд байршуулах | - | - Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын мэдээллийн самбар болон цахим хуудсаар дамжуулж Авлигын эсрэг хууль тогтоомжийн мэдээ мэдээллийг хүргэж, дүүргийн төрийн албан хаагчдыг "Авлигатай тэмцэх газар" болон "АТГ-олон нийтийн төв" фэйсбүүк пэйж хуудсанд нэгдүүлэн холбогдох мэдээ мэдээллийг авч ажиллаж байна. Дүүргийн "Сонгинохайрхан Мэдээ" нэртэй фейсбүүк пейж хуудсаар дамжуулан богино хэмжээний 3 бичлэг, 10 постер (Авлигагүй нийгэм бичний ирээдүй, Би өгөхгүй-Би авахгүй, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байцгаая", Авлигагүй нийгмийг хамтдаа бүтээе, Авлигад үгүй гэж хэлцгээе, Авлигын эсрэг нэгдье, Үгүй гэж хэлээд өөрчилье, Шударга ёс-Хөгжил дэвшилд 110") бэлтгэн олон нийтэд түгээн ажилласан.<br>- Мөн дүүргийн Засаг даргын дэргэдэх болон эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагууд | 100 | ТЗУХ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллагын албан ёсны пэйж хуудас болон мэдээллийн самбаруудад Авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа, Гомдол мэдээлэл хүлээн авах утас 110 зэрэг постер, шторк, рийл зэргийг байршуулж, АТГ-аас гаргасан бичлэг, санамж, зөвлөмжийг лед дэлгэцээр гаргаж олон нийтэд соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулсан. | | |
| | | 1.2.Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах | -Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх;<br>-Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх;<br>-Хамтран ажилласан байгууллага, хүний тоо;<br>-Үр дүнг тооцсон байх. | Жилдээ | 2 өдөрлөг, 1 аян | - | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, удирдах албан тушаалтны авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг дэмжих, албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, авлигыг үл тэвчих, үл эвлэрэх хандлагыг төлөвшүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх, иргэдийг мэдээ мэдээллээр хангах зорилгоор "Авлигын эсрэг нэгдье" аяныг дүүргийн Засаг даргын дэргэдэх болон эрхлэх асуудлын хүрээний харьяа 23 байгууллагын дунд 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл 1 сарын хугацаатай зохион байгуулсан. | 80 | ТЗУХ |
| | | 1.3.Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд | -Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх;<br>-Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; | Сар бүр | 1200 ш гарын авлага тараах | - | "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлье" сэдэвт сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр дүүргийн нутгийн захиргааны нийт байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд, албан хаагчдыг оролцуулан зохион байгуулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн төрийн албан хаагчдад | 85 | ТЗУХ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах | -Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх;<br>-Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. | | | | 1000 ширхэг гарын авлага, танилцуулгыг тараан ажилласан. | | |
| | | 1.4.Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх | -Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх;<br>-Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх;<br>-Олон нийтэд түгээсэн байх. | 2, 3 дугаар улиралд | 12-оос доошгүй | - | Хүнс худалдаа үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагаанд хамаарах аж ахуй нэгжийн архи, тамхины тусгай зөвшөөрөл олгох Зөвлөлийн хурлыг нийтэд ил тод шууд дамжуулалтаар хийж сонгон шалгаруулснаар авлигад өртөж болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж байна.<br>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, 110 дугаарын утсыг сурталчлах чиглэлээр 10 төрлийн постер (Авлигагүй нийгэм бидний ирээдүй, Би өгөхгүй-Би авахгүй, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байцгаая", Авлигагүй нийгмийг хамтдаа бүтээе, Авлигад үгүй гэж хэлцгээе, Авлигын эсрэг нэгдье, Үгүй гэж хэлээд өөрчилье, Шударга ёс-Хөгжил дэвшилд 110"), хууль тогтоомжийг таниулах чиглэлээр 3 удаагийн богино бичлэгийг бэлтгэн төрийн албан хаагч, иргэд олон нийтэд түгээн ажилласан. | 100 | ТЗУХ |
| | 2.Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн | 2.1."Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх | -Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх;<br>-Сонгосон чиглэлд олон нийтийг | Жилдээ | 1-ээс доошгүй | - | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах зорилгын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран shilen.gov.mn мэдээлэл байршуулах арга зүйн сургалтыг 1 удаа зохион байгуулж, нийт 12 байгууллагын 24 албан | 100 | ТЗУХ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналтыг хэрэгжүүлэх | | хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх;<br>-Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах;<br>-Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх. | | | | хаагчийг хамруулсан. Дүүргийн Засаг даргын 2025 оны А/657 дугаар захирамжаар Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагын нээлттэй мэдээллийн цахим системийг хариуцан ажиллах албан хаагчийг томилж, мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж, хэрэгжилтийг ханган ажиллах арга хэмжээг зохион байгуулан ажилласан. | | |
| | | 2.2.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх | -Салбар бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх;<br>-Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх;<br>-Үр дүнг тооцож, тайлагнасан байх. | Жилдээ | 4-өөс доошгүй | - | Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагын судалгааг гаргаж нийт 27 байгууллагын мэдээллийг нэгтгэсэн. 2025 онд хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Зөв найзууд" ТББ, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв", "Тэнгэрлэг монголын газар шороо" ТББ зэрэг нийт 3 байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, зохион байгуулах үйл ажиллагааны чиглэлийг батлуулж ажилласан. | 50 | НХХ |
| | | 2.3.Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах | -2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх;<br>-Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч, | Жилдээ | 12-оос доошгүй нээлттэй мэдээлэх | - | 2025 онд төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авалтын төлөвлөгөөг 01 дүгээр сарын 14-ний өдөр shilendans.gov.mn сайтад нээлттэй ил, тод байршуулсан. 2025 онд Нийслэл, НОНХС, Дүүрэг, ДОНХС, урсгал төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээ нь жилийн эцсийн байдлаар 87,345,700,910 (Наян долоон тэрбум гурван зуун дөчин таван сая долоон зуун мянга есөн зуун арав) төгрөгийн төсөвт өртөг бүхий 219 төсөл, арга хэмжээг 100 хувь цахимаар зохион байгуулж, давхардсан тоогоор 315 урилга, 315 үр дүнг тухай бүрд | 100 | ХААА |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох арга хэмжээг авах;<br>-Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх. | | | | хуулийн хугацаанд цахим системд ил тод, нээлттэй нийтэлсэн.<br>Мөн байгууллагын албан ёсны олон нийтийн сүлжээ “Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны алба” фэйсбүүк хуудсаар дамжуулан тендер шалгаруулалттай холбоотой 29 мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод, ойлгомжтой байдлаар түгээн ажилласан. | | |
| | | 2.4.Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших | -Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах;<br>-Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших;<br>-Иргэд, олон нийтээс Байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх. | Жилдээ | 2-оос доошгүй | - | Төрийн байгууллагын хүнд суртал, сахилга хариуцлагыг дээшлүүлэхээр өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад зөрчил дутагдал гаргасан 9 байгууллагын 7 албан хаагчдад анхааруулга өгч, 2 албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулсан. Төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр харьяа байгууллагуудад чиглэл, зөвлөмжийг хүргүүлж, 43 хороодын зохион байгуулагч нарт албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн үр чадвар дээшлүүлэх, арга зүйн сургалтыг зохион байгуулсан. Дүүргийн хэмжээнд нийт 4587 өргөдөл, гомдол ирснээс судалж байгаа 93, шийдвэрлэсэн 4490, Хуулийн хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 4 байна. Үүнээс иргэний талд шийдвэрлэсэн 3193, боломжгүй хариу өгсөн 1297. Мөн дүүргийн хэмжээнд хуулийн хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 4 өргөдөл бүртгэгдсэнээс өмнөх оны мөн энэ үетэй харьцуулахад 9 буюу 55 хувиар буурсан байна.<br>Мөн иргэдийн өргөдөл гомдол ихээр ирдэг Хөдөлмөр, халамжийн | 100 | ТЗУХ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлчилгээний хэлтэс, Нийгмийн даатгалын газар, Татварын хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэст 2025 оны 04 дүгээр сард хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж зөвлөмж хүргүүлсэн. | | |
| | | 2.5.Улс, орон нутаг, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгох | -MNS 7023:2023 "Мэдээллийн самбар"-т тавигдах шаардлага бүхий үндэсний стандартын хэрэгжилтийг улсын хэмжээнд хангуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах. | Жилдээ | Тухай бүр | - | Дүүргийн хэмжээнд 2025 онд Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр тохижилт бүтээн байгуулалтын чиглэлээр 186 ажил хийгдсэн. Үүнээс: Авто зам, замын бүтээн байгуулалтын чиглэлээр дүүрэг, нийслэлийн төсвөөр 8, дэд бүтэц, инженерийн байгууламжийн чиглэлээр 4, тохижилт бүтээн байгуулалтын чиглэлээр 36, дулаан автобусны буудал 10, байр орон сууцны засварын ажил 19, цахилгаан эрчим хүчний хүчдэл сайжруулах чиглэлээр 14 ажил, худаг усан сан барих 6, дүүргийн 43 хороонд 88 бүтээн байгуулалтын ажил г.м.<br>Дүүргийн хэмжээнд хийгдсэн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад MNS 7023:2023 "Мэдээллийн самбар"-т тавигдах шаардлага бүхий үндэсний стандартын хэрэгжилтийг хангуулан ажилласан. | 80 | ХСТНААХ |
| | 3.Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 3.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга | -Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах;<br>-Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх;<br>-Хэрэгжилтийг тайлагнах. | Жилдээ | 4-оос доошгүй | - | Дүүргийн хэмжээнд "Хурдан цэг"-ийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 18 хороонд "Хурдан цэг" нэмж байгуулсан бөгөөд 384.0 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг дүүргийн 43 хороонд угсарч суурилуулсан. Төрийн үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран 43 хорооны "Хурдан цэг"-ийн үйл ажиллагааг хянаж, 43 байгууллагын 453 төрлийн үйлчилгээг үзүүлж байна. | 100 | ТЗУХ ГЗБА |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээг зохион байгуулах | | | | | Толгойт, Тахилт, Баруун салаа, Содон хороолол зэрэг алслагдсан болон хүн ам шигүү суурьшсан байршилд хөдөлгөөнт "Хурдан цэг"-ийг түр хугацаанд байршуулж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулсан. "E-MONGOLIA" портал сүлжээний хэрэглээг олон нийтэд сурталчлах чиглэлээр 10 удаагийн мэдээ танилцуулгыг бэлтгэж дүүргийн сайтаар түгээсэн.<br>Газар зохион байгуулалтын ажлын хүрээнд 2000-2024 оны захирамжуудыг www.shilen.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй нийт 35 үйлчилгээ цахимжсан. E-Gazar цахим системээр газартай холбоотой 23 төрлийн үйлчилгээг үзүүлж байна. | | |
| | | 3.2.Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх | -Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших;<br>-Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх;<br>-Эрсдэлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын үйл | Жилдээ | Тухай бүр | - | -"Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргасан албан хаагчдын "баталгааны маягт" хүлээн авах хуваарь"-ийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, 2025 оны 01-р сарын 16-ны өдрөөс 02-р сарын 15-ны өдрүүдэд хуваарийн дагуу хүлээн авч баталгаажуулсан.<br>2025 оны байдлаар нийт 93 удирдах болон эрх бүхий албан тушаалтны ХАСХОМ, ХАСУМ мэдүүлсэн бөгөөд үүнээс ХАСУМ-33, ХАСХОМ-60 мэдүүлсэн байна. Дээрх 93 мэдүүлэг гаргагчийн мэдүүлэгт хяналт тавьж, баталгаажуулан, заавар зөвлөгөө өгч ажилласан. Газар зохион байгуулалтын албаны иргэдэд үзүүлж буй үйлчилгээний талаарх иргэдийн санал сэтгэгдлийг авах зорилгоор албан хаагчдын цонхон дээр сэтгэл ханамжийн | 80 | ТЗУХ<br>ГЗБА |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллагааг зохион байгуулсан байх. | | | | судалгааны QR кодыг байршуулсан. Судалгаанд 23 иргэн хамрагдаж, санал хүсэлтээ ирүүлсэн байна. Тус албанаас үйлчилгээ авч байгаа иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг бүртгэж, буцах хуудас өгч ажиллаж байна. | | |
| | | 3.3.Нийслэлийн хэмжээнд Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах | -Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>-Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг тусгасан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | - | - | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/368 дугаар захирамжаар дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилт, 16 арга хэмжээтэйгээр боловсруулан баталж, дүүргийн төр захиргааны нийт байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийг хангуулж ажилласан бөгөөд хэрэгжилт 85 хувьтай байна. | 85 | ТЗУХ |
| | | 3.4.Хүүхдийн шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах | -Сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх. | Жилдээ | - | 10,617,000 | "Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих" төслийг боловсруулан дүүргийн ИТХ-ын 2025 оны 32 дугаар тогтоолоор батлуулж, 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилт, 12 арга хэмжээтэйгээр боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Төслийн хүрээнд "Мөрөөдөлд хүрэх зам" ахлах ангийн сурагчдын манлайлах, нөлөөлөх, бүтээлчээр сэтгэх, мэргэжил сонголттой холбоотой, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох ур чадварыг хөгжүүлэх, өсөж дэвжих хандлага суулгах зорилготой цуврал арга хэмжээг 5 хоногийн хугацаанд зохион байгуулж, дүүргийн ерөнхий боловсролын 26 сургуулийн нийт 2000 гаруй ахлах ангийн сурагчдыг хамруулж ажиллалаа. 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Соёл түгээе-Соёлтой Сонгинохайрханчууд аяны хүрээнд Засаг даргын эрхлэх | 90 | НХХ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | асуудлын хүрээний байгууллага болон хороодын нийт 400 гаруй алба хаагчдад "Байгууллагын соёл-Харилцаа хандлага" сэдвээр бүсчилсэн сургалт хийсэн. | | |
| | | 3.5.Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөөнд санал өгөх, хэрэгжилтийг зохион байгуулах, | -Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас санал авч, нэгтгэн хүргүүлсэн байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | - | - | Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгах ажлын саналыг боловсруулж хүргүүлсэн. Тус санал 12 чиглэлээр 17 ажлын саналыг хүргүүлсэн. | 100 | ХЭЗХ |
| | | 3.6.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийх | -Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;<br>-Дүгнэлт зөвлөмж гаргасан байх. | Жилдээ | - | - | Дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллага Худалдан авах ажиллагааны алба, Дэд бүтцийн хөгжлийн алба, Захиалагчийн алба, Дотоод аудитын албаны 2024 оны ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийж ажилласан.<br>Дүүргийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/193 дугаар захирамжаар дүүргийн Нийгмийн даатгалын газар, Татварын хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дотоод үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлыг зохион байгуулан зөвлөмж хүргүүлэн ажилласан.<br>Архивын улсын үзлэг зохион байгуулах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын дэргэдэх болон эрхлэх асуудлын хүрээний харьяа 23 байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөн тусалж ажилласан. | 100 | ХШҮХ |
| | | 3.7.Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан | -Эх үүсвэрийн тоог нэмэгдүүлж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн | Жилдээ | - | - | Дүүргийн удирдлага иргэдээ сонсох, иргэдээс гаргасан саналыг бодлого үйл ажиллагаандаа тусгах ажлын хүрээнд Засаг даргын А/19 | 100 | ТЗУХ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулах | хяналтыг сайжруулж, 7 хоног тутам мэдээ, мэдээллийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудад танилцуулах. | | | | дүгээр захирамжаар иргэдтэй уулзах хуваарийг баталсан. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдол санал хүсэлтэд шуурхай хариу өгөх, хэрэгжилтэд хяналт тавих Ажлын хэсэг, иргэдтэй хийх уулзалтын журмыг А/162 дугаар захирамжаар баталж 2 удаагийн хуралдааныг зохион байгуулан биелэлтэд хяналт тавьж, анхаарах асуудлын талаар хэлэлцэж ажилласан. Жилийн эцсийн байдлаар нийт 12 удаагийн уулзалтыг зохион байгуулж, 132 иргэний санал, хүсэлтийг шийдвэрлэсэн байна.<br>Нутгийн захиргааны байгууллагын "ERP" цахим системээс гадна дүүргийн албан ёсны www.shd.ub.gov.mn цахим сайт, songinokhairkhandistrict@gmail.com мэйл хаяг, (70173317) тусгай дугаараар дамжуулж санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, хариуг хүргүүлж байна. Дүүргийн хэмжээнд иргэдтэй хийх уулзалтын постер болон "Бид иргэдээ сонсож, шийднэ" постерыг тус тус бэлтгэж, байгууллагын цахим хаягт байршуулсан.<br>Засаг даргын Тамгын газар нь TelcoCom харилцаа холбооны нэгдсэн системийг 2024 оны 11 сараас эхлэн үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэн. Жилийн эцсийн байдлаар нийт 19265 дуудлага ирснээс хамгийн их дуудлага хүлээн авсан угтах үйлчилгээ 4310, өргөдөл, гомдол 3614, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст 1909 байна. Үүнээс хариулсан 16170, хариулаагүй 2315, алдсан дуудлага 780 байна. Энэхүү үйлчилгээг нэвтрүүлснээр иргэдэд | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, гомдлын тоо буурахаас гадна байгууллагын дуудлагын тайлан мэдээ гаргах, хяналт тавих зэрэг олон давуу тал бий болсон. | | |
| | | 3.8.Нийслэлийн удирдах ажилтны шуурхай хуралдаанаар өгсөн үүрэг даалгавар, Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах | -Засаг даргын захирамж, ажлын хэсэг, албан тушаалтанд өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцсон байх. | Жилдээ | - | - | Дүүргийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/18 дугаар захирамжаар Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 2025 онд 23 удаа зохион байгуулан 427 үүрэг даалгавар өгөгдөж, хэрэгжилтийн дундаж 71 хувьтай байна. | 78 | ХШҮХ |
| | | 3.9.Худалдан авах ажиллагааны А3 сургалтад хамрагдах албан хаагчийн тоог нэмэгдүүлэх | -Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо. | Жилдээ | 100 | - | Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/15 дугаар тушаалаар 16 албан хаагчийг, 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/157 дугаар тушаалаар 11 албан хаагчийг тус тус Худалдан авах ажиллагааны А3 сертификат авах сургалтад хамруулсан. Хоёр удаагийн сургалтад нийт 27 албан хаагч хамрагдаж, 9 албан хаагч шалгалтад тэнцэн А3 гэрчилгээ авсан. | 100 | ТЗУХ<br>ТГУХ |
| | | 3.10.Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах | -Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн сангийн үйл ажиллагаанд хяналтыг тогтмол хийж хэвшсэн байх. | Жилдээ | - | | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа бөгөөд дүүргийн төсөвт 128 байгууллагын Төсвийн шууд захирагч нарт Засаг даргын 2025.09.29-ний өдрийн 01/3355 дугаар албан бичгээр “Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн дагуу төсвийн зардлын хэмнэлтийг хэрэгжүүлэн, төсвийн сахилга бат, дотоод хяналтыг сайжруулан ажиллах тухай мэдэгдэл”-ийг хүргүүлсэн. Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, НИТХ-ын 2025 оны 25/50 | -<br>100 | СТСХ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/552 дугаар захирамж, Дүүргийн ИТХ-ын 2025 оны 39 дүгээр тогтоол болон бусад холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн дүүргийн төсвийн сарын хуваарийг дүүргийн Засаг даргын 2025 оны А/305 дугаар захирамжаар батлуулан холбогдох байгууллагуудад хүргүүлэн сар бүр санхүүжилтийг хуваарийн дагуу олгон ажиллаж байна. | | |
| | | 3.11.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулах | -Нийслэлийн удирдах албан тушаалтнуудад зориулсан сургалт зохион байгуулсан байх;<br>-Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулсан байх;<br>-Нийслэлийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн албан хаагч нарт зориулсан сургалт зохион байгуулсан байх;<br>-Иргэний нийгмийн байгууллага (Иргэн, сонирхлын бүлэг, ТББ, мэргэжлийн холбоо г.м)-д чиглэсэн сургалт зохион байгуулсан байх;<br>-Хувийн хэвшилд зориулсан сургалт зохион байгуулсан байх. | Жилдээ | - | 7,788,000 | Дүүргийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн "Сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах тухай" А/384 дүгээр захирамжийн дагуу Авлигатай тэмцэх газартай хамтран төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх талаар "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлье" сэдэвт сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр дүүргийн нутгийн захиргааны нийт байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулан зохион байгуулж, 650 албан хаагчийг хамруулсан.<br>Мөн дүүргийн Цагдаагийн газар, Нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Худалдан авах ажиллагааны алба, Дотоод аудитын алба, Биеийн тамир спортын хороо, Сонгинохайрхан нэгдсэн эмнэлэг, СХД-ийн Эрүүл мэндийн төв, Газар зохион байгуулалтын алба, "Баруун бүсийн зам засвар арчлалтын газар" ОНӨААТҮГ, "Теле камерын хяналтын дэд төв" ОНӨТҮГ зэрэг байгууллагуудын 400 гаруй | 100 | ТЗУХ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажилтан, алба хаагчдыг ашиг сонирхлын зөрчил, авлига, албан тушаалын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хор уршгийг таниулах чиглэлээр сургалт соён гэгээрүүлэх ажил зохион байгуулсан байна. | | |
| | | 3.12.Төрийн болон албаны нууцын тухай, хадгалалт хамгаалалт талаар сургалт зохион байгуулах | -Нийслэлийн удирдах албан тушаалтнуудад зориулсан сургалт зохион байгуулсан байх;<br>-Нэгдсэн төслийн удирдлагын газар ОНӨТҮГ-ын албан хаагчдад зориулсан зохион байгуулсан байх. | Жилдээ | 2-оос доошгүй | - | Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1378, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2024 оны А/712 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хороодод цэргийн бүртгэл явуулах албан тушаалтнуудад "Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалт" сэдвээр 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. Сургалтад дүүргийн 1-43 дугаар хорооны Зохион байгуулагчид хамрагдсан бөгөөд мэдээллийн аюулгүй байдлыг хангах, нууц баримт бичгийн хадгалалт, хамгаалалт болон хүлээх хариуцлагын талаар мэдээлэл өгсөн. | 100 | ЦШ |
| | | 3.13.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, үр дүн тооцох, холбогдох арга хэмжээ авч хариуг хүргүүлэх | -АТГ-аас хүргүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр үр дүнтэй ажиллах, үр дүнг тооцож хүргүүлэх;<br>-АТГ-аас хүргүүлсэн зөрчил арилгуулах албан бичгийн мөрөөр үр дүнтэй ажиллах, үр дүнг тооцож хүргүүлэх;<br>-Тухайн байгууллагатай холбоотой хэвлэл мэдээллийн мөрөөр АТГ-тай хамтран ажиллах, холбогдох | Жилдээ | Тухай бүр | - | -Авлигатай тэмцэх газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 06/9737 дугаар албан бичиг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 05-02/3682 дугаартай албан бичгээр "Бусдын зардлаар гадаад улсад албан томилолтоор зорчсон албан тушаалтнуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож хариу ирүүлэх тухай" мэдэгдсэн. Тус албан бичгийн дагуу холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцон, 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 03/2284 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн. | 100 | ТЗУХ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | баримт бичгийг гаргаж хүргүүлэх;<br>-Тухай байгууллагын үйл ажиллагаанд тандалт, дүн шинжилгээ хийхэд АТГ-тай хамтран ажиллах, холбогдох баримт бичгийг гаргаж хүргүүлэх;<br>-Тухай байгууллагын үйл ажиллагаатай холбоотой АТГ-т өргөдөл, гомдол, мэдээлэл ирэхэд хамтран ажиллах, холбогдох баримт бичгийг гаргаж өгөх. | | | | -Мөн Авлигатай тэмцэх газрын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 03/13739 дугээр албан бичиг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 01/5253 дугаартай албан бичгийн дагуу "Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч, Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ." гэж заасныг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож хариу ирүүлэх тухай" мэдэгдсэн. Тус албан бичгийн дагуу холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцон, 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 03/3013 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн. | | |
| | | 3.14.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр батлах дүрэм, журмын жагсаалтыг гаргаж, Авлигатай тэмцэх газраас санал авч, тусгасан байх | -АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, албан бичгийн дагуу хариуг хүргүүлж, өөрчлөх, хүчингүй болгох;<br>-Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас санал авч, нэгтгэн хүргүүлсэн байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | Тухай бүр | | - Тухайн онд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр батлах дүрэм, журмын төсөлд санал авахаар албан бичиг ирүүлээгүй.<br>- НЗДТГ-аас ирүүлсэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны "Мэдээлэл хариуцагчийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх журмын төсөл", Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам", Эдийн засаг, хөгжлийн яамны "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл", Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас | 100 | ХЭЗХ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулж буй “Сууц өмчлөгчдийн холбооны үлгэрчилсэн дүрмийн төсөл”-д тусгуулах саналыг тухай бүр хүргүүлсэн байна. | | |
| | | 3.15.Улаанбаатар хотод хэрэгжүүлэх Мега төслүүдийн хэрэгжилтэд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, хяналт тавьж ажиллах | -АТГ-тай хамтран Мега төслүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулах. | Жилдээ | Тухай бүр | - | - | - | - |
| **Хэрэгжилтийн дундаж хувь: 92,5%** | | | | | | | | | |

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА А.БЯМБА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ХҮНИЙ НӨӨЦ, ЁС ЗҮЙ, ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.МӨНХЦЭЦЭГ